

МОНГОЛ ГАЗРЫН ТОС  
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 07 өдөр

№ А/24

Улаанбаатар хот

Байгууллагын нууцад хамаарах  
мэдээллийн жагсаалт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.10, Байгууллагын нууцын тухай хуулийн 4.2, 5.1, Компанийн нууцын тухай журмын 1.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. Байгууллагын нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг нийт ажиллагсдад танилцуулж, хяналт тавьж ажиллахыг Захиргааны газар (О.Энхбаяр)-т даалгасугай.


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ДАЛТАНЦЭЦЭГ



“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр”  
ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 02..  
дугаар сарын 07 -ны өдрийн А/1 тоот тушаалын  
хавсралт



## БАЙГУУЛЛАГЫН НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нууцад хамаарах мэдээлэл
1	Ажиллагсдын хувийн хэрэг, хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалсан хувь хүний мэдээлэл
2	Компанийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн баримтууд
3	Үйлдвэрийн технологийн болон дагалдах хангамжийн байгууламжуудын инженерчлэл, зураг төсөл, холбогдох техникийн баримт бичиг <ul style="list-style-type: none"><li>- BDEP-Ерөнхий зураг төсөл, инженерчлэлийн багц,</li><li>- FEED-суурь инженерчлэлийн зураг төсөл,</li><li>- Detailed engineering-Ажлын зураг төсөл,</li><li>- Residual engineering-Бусад зураг төсөл,</li></ul>
4	Газрын тос боловсруулах үйлдвэр, хотхон, дамжуулах хоолойн бүтээн байгуулалт болон газрын тосны хайгуул судалгааны чиглэлээр хамтран ажиллах компаниудыг сонгон шалгаруулсан Тендерийн баримт бичгүүд
5	ГТБҮ-ийн хотхоны барилгын ажлын зураг төсөл, ажлын баримт бичгүүд
6	Дэд бүтцийн ажлын талаарх мэдээлэл, автозам, төмөр замын суурь бүтэц ашиглуулах тариф
7	1. Дамжуулах хоолойн технологийн болон дагалдах хангамжийн байгууламжуудын инженерчлэл, зураг төсөл болон бусад холбогдох техникийн баримт бичиг <ul style="list-style-type: none"><li>- ерөнхий зураг төсөл, инженерчлэлийн багц, суурь инженерчлэлийн зураг төсөл, ажлын зураг төсөл</li></ul> 2. Инженерчлэлийн ажил, технологийн баримт бичиг
8	Үйлдвэр, хотхон, дамжуулах хоолойн бүтээн байгуулалт болон газрын тосны хайгуул судалгааны чиглэлээр хийгдсэн гэрээ, хэлцлүүд, тэдгээрийн үйл ажиллагаатай холбоотой баримт
9	Хайгуулын ажлын анхдагч өгөгдөл, боловсруулалт хийгдсэн тайлан, мэдээ
10	Ажлын зориулалт бүхий дотоод сүлжээ, сервер, программ хангамж, дата